



САНГИЙН САЙД  
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛТ**

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,  
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16,  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2019. 02. 28 № 08

**Асуулт тавих тухай**

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хот төдийгүй аймгийн төвүүдийн агаарын бохирдол нэмэгдэж, ялангуяа өвлийн улиралд Улаанбаатар хотын агаарын бохирдол хэвийн хэмжээнээс хэд дахин нэмэгдэж хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдал ноцтой эрсдэлд хүрээд байна. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, хөрсний бохирдлоос хамгаалах хамгийн оновчтой шийдлийн нэг нь гэр хорооллыг дэд бүтцээр хангах төсөл юм. Улсын хэмжээнд Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороонд гэр хорооллыг бие даасан болон хэсэгчилсэн инженерийн хангамжаар хангах “Дэд бүтцийн төв” төсөл нь амжилттай хэрэгжиж 285 айлын 14 га газарт агаар, хөрсний бохирдлыг бууруулах бодит шийдэл болж байгаа билээ. Цаашид энэ төслийг хотын гэр хороолол болон орон нутагт хэрэгжүүлэх нь агаар, орчны бохирдлыг бууруулахад ихээхэн ач холбогдолтой юм

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.3-т заасан бүрэн эрхийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Дэд бүтцийн салбарын хүрээнд” авч хэрэгжүүлэх арга хэмжээнд гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ гэж заасантай холбогдуулан Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын инженерийн дэд бүтцийг сайжруулах, инженерийн дэд бүтэц хүрэлцээгүй бүсүүдэд БХБЯ, НЗДТГ-аас “Сервис центр” дэд төвүүдийг байгуулах төслийн санхүүжилтийг БНХАУ-ын буцалтгүй тусlamжийн 2 тэрбум юанийн хүрээнд шийдвэрлэх Засгийн газрын 2017 оны 179 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар тодорхой мэдээллийг ирүүлнэ үү.


Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэх, улмаар Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

М.ОЮУНЧИМЭГ

С.БЯМБАЦОГТ



0000000019